



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/100-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитын гүйцэтгэсэн: Пийк Ом Аудит ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАРУУНБҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.ЭНХТУЯА ТАНАА

2023.02.25 № 107-2023/10-10-17-143
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 83.6 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 174,015.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20,919.2 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 7,658.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 16.4 хувиар хэмнэгдсэн байна.

018020133

Аудитын гол асуудал

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 70.6 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 11.6 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Тус байгууллага нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 5 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд хамрагдаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,394,060.2	284,373,206.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		205,922,233.4
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		205,922,233.4
3121	Төгрөг		205,922,233.4
31211	Төрийн сангийн харилцах		205,922,233.4
35	БАРАА МАТЕРИАЛ	71,394,060.2	78,450,973.5
351	Түүхий эд материал	626,800.0	626,800.0
3513	Эм боох материал	626,800.0	626,800.0
354	Хангамжийн материал	70,767,260.2	77,824,173.5
3541	Бичиг хэргийн материал	14,532,999.7	18,246,557.0
3542	Аж ахуйн материал	56,234,260.5	59,577,616.5
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	836,078,128.3	953,529,058.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	836,078,128.3	953,529,058.5
392	Биет хөрөнгө	814,350,361.7	932,113,791.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	741,412,729.0	863,409,012.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,611,966.2)	(97,382,390.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.0	14,562,500.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.0)	(14,562,500.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,153,509.0	195,374,068.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(112,801,011.5)	(123,084,765.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,873,813.4	120,873,813.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,098,659.1)	(72,139,848.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,767,889.0	26,767,889.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,811,039.6)	(5,081,386.1)
39217	Ном	20,465,097.6	23,377,400.0
393	Биет бус хөрөнгө	21,727,766.6	21,415,266.6
39301	Програм хангамж	1,800,000.0	1,800,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,070,833.4)	(1,383,333.4)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,998,600.0	20,998,600.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	907,472,188.5	1,237,902,265.4
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	907,472,188.5	1,237,902,265.4
51	Засгийн газрын хувь оролцоо	907,472,188.5	1,237,902,265.4
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	605,059,296.3	605,059,296.3
512	Хуримтлагдсан үр дүн	(22,266,339.4)	308,163,737.4
5121	Өмнөх үеийн үр дүн	(22,266,339.4)	(22,266,339.4)
5122	Тайлант үеийн үр дүн		330,430,076.9
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	324,679,231.7	324,679,231.7
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	907,472,188.5	1,237,902,265.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	954,169,108.3	1,458,191,184.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,182,328.1	142,629,606.7
120	Нийтлэг татварын бус орлого	45,182,328.1	142,629,606.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,182,328.1	142,629,606.7
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,182,328.1	142,629,606.7

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,986,780.2	1,315,561,577.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	807,614,100.0	1,143,264,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	807,614,100.0	1,143,264,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,164,800.0	5,286,300.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,795,000.0	2,518,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,369,800.0	2,768,300.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,207,880.2	167,010,877.3
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,207,880.2	167,010,877.3
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	940,059,588.9	1,127,761,107.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,059,588.9	1,127,761,107.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,251,065.9	1,070,304,857.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,496,935.8	695,959,169.8
210101	Үндсэн цалин	453,757,351.8	507,429,532.7
210102	Нэмэгдэл	96,472,805.9	144,664,949.1
210104	Урамшуулал	35,266,778.0	43,864,688.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,040,541.2	87,827,840.2
210201	Тэтгэврийн даатгал	55,167,062.8	60,061,239.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,106,969.8	7,070,722.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,737,735.5	5,592,737.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,184,434.1	1,373,012.9
210205	Эрүүл мэндийн даатгал	11,844,339.0	13,730,127.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,207,880.2	128,874,923.9
210301	Гэрэл, цахилгаан	4,398,650.0	8,460,583.3
210302	Түлш, халаалт	80,821,830.3	110,924,340.6
210303	Цэвэр, бохир ус	8,987,400.0	9,490,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,942,088.7	1,631,019.0
210401	Бичиг хэрэг	223,000.0	397,300.0
210402	Тээвэр, шатахуун	1,795,250.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,111,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,969,900.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	308,600.0	1,233,719.0
210408	Бараа материал акталсны зардал	6,534,338.7	
2105	Нормативт зардал	28,244,100.0	63,491,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	343,300.0	
210502	Хоол, хүнс	27,900,800.0	63,491,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,050,200.0	860,100.0
210604	Урсгал засвар	2,050,200.0	860,100.0
2107	Томилолт, зочны зардал	262,000.0	128,600.0
210702	Дотоод албан томилолт	262,000.0	128,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,032,700.0	7,694,625.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,024,700.0	5,654,625.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,040,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,974,620.0	83,836,979.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	277,800.0	19,738,860.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,104,670.0	11,419,905.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,592,150.0	52,678,214.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,808,523.0	57,456,250.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,404,800.0	57,456,250.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,004,800.0	57,456,250.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.0	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,403,723.0	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,403,723.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	14,109,519.4	330,430,076.9
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,079,160.0	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,079,160.0	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,079,160.0)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,030,359.4	330,430,076.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	908,986,780.2	1,315,561,577.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,986,780.2	1,315,561,577.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	807,614,100.0	1,143,264,400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	807,614,100.0	1,143,264,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,164,800.0	5,286,300.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,795,000.0	2,518,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,369,800.0	2,768,300.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,207,880.2	167,010,877.3
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,207,880.2	167,010,877.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	883,744,605.2	1,075,897,943.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	883,744,605.2	1,075,897,943.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	806,936,082.2	1,018,441,693.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,986,935.8	695,959,169.8
210101	Үндсэн цалин	454,247,351.8	507,429,532.7
210102	Нэмэгдэл	96,472,805.9	144,664,949.1
210104	Урамшуулал	35,266,778.0	43,864,688.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,040,541.2	87,827,840.2
210201	Тэтгэврийн даатгал	55,167,062.8	60,061,239.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,106,969.8	7,070,722.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,737,735.5	5,592,737.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,184,434.1	1,373,012.9
210205	Эрүүл мэндийн даатгал	11,844,339.0	13,730,127.6

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,207,880.2	128,874,923.9
210301	Гэрэл, цахилгаан	4,398,650.0	8,460,583.3
210302	Түлш, халаалт	80,821,830.3	110,924,340.6
210303	Цэвэр, бохир ус	8,987,400.0	9,490,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,867,900.0	
210401	Бичиг хэрэг	661,500.0	
210402	Тээвэр, шатахуун	1,795,250.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,164,150.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	432,900.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,814,100.0	
2105	Нормативт зардал	29,917,500.0	63,491,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	267,600.0	
210502	Хоол, хүнс	27,900,800.0	63,491,600.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,749,100.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		860,100.0
210604	Урсгал засвар		860,100.0
2107	Томилолт, зочны зардал	262,000.0	
210702	Дотоод албан томилолт	262,000.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,153,625.0	4,808,300.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,145,625.0	2,768,300.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,040,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,499,700.0	36,619,760.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		23,852,060.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,499,700.0	12,767,700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,808,523.0	57,456,250.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,404,800.0	57,456,250.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,004,800.0	57,456,250.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.0	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,403,723.0	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,403,723.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	25,242,175.0	239,663,633.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	25,242,175.0	33,741,400.0
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	25,242,175.0	33,741,400.0
	Дотоод эх үүсвэрээр	25,242,175.0	33,741,400.0
221001	Их засвар	10,354,200.0	3,143,400.0
222001	Тоног төхөөрөмж	14,000,000.0	30,598,000.0
223001	Бусад хөрөнгө	887,975.0	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,242,175.0)	(33,741,400.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		205,922,233.4
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		205,922,233.4

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.3	324,679,231.7	(34,256,698.9)	895,481,829.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,040,000.0)	(1,040,000.0)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
7	Тайлант үеийн үр дүн			13,030,359.4	13,030,359.4
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.3	324,679,231.7	(22,266,339.4)	907,472,188.5
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			330,430,076.9	330,430,076.9
19	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.3	324,679,231.7	308,163,737.4	1,237,902,265.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,326,808,600.0	1,109,639,343.9	217,169,256.1	83.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,326,808,600.0	1,109,639,343.9	217,169,256.1	83.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,261,693,700.0	1,052,183,093.9	209,510,606.1	83.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,975,100.0	695,959,169.8	174,015,930.2	80.0
210101	Үндсэн цалин	639,420,600.0	507,429,532.7	131,991,067.3	79.4
210102	Нэмэгдэл	203,947,200.0	144,664,949.1	59,282,250.9	70.9
210104	Урамшуулал	26,607,300.0	43,864,688.0	(17,257,388.0)	164.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,747,100.0	87,827,840.2	20,919,259.8	80.8
210201	Тэтгэврийн даатгал	73,948,100.0	60,061,239.4	13,886,860.6	81.2
210202	Тэтгэмжийн даатгал	8,699,700.0	7,070,722.6	1,628,977.4	81.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,959,700.0	5,592,737.8	1,366,962.2	80.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,740,000.0	1,373,012.9	366,987.1	78.9
210205	Эрүүл мэндийн даатгал	17,399,600.0	13,730,127.6	3,669,472.4	78.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,653,600.0	128,874,923.9	1,778,676.1	98.6
210301	Гэрэл, цахилгаан	10,436,300.0	8,460,583.3	1,975,716.7	81.1
210302	Түлш, халаалт	111,176,800.0	110,924,340.6	252,459.5	99.8
210303	Цэвэр, бохир ус	9,040,500.0	9,490,000.0	(449,500.0)	105.0
2105	Нормативт зардал	66,743,600.0	63,491,600.0	3,252,000.0	95.1
210502	Хоол, хүнс	66,743,600.0	63,491,600.0	3,252,000.0	95.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,003,500.0	4,003,500.0		100.0
210604	Урсгал засвар	4,003,500.0	4,003,500.0		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,280,100.0	4,808,300.0	6,471,800.0	42.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,768,300.0	2,768,300.0		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,511,800.0	2,040,000.0	6,471,800.0	24.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,290,700.0	67,217,760.0	3,072,940.0	95.6

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,523,000.0	54,450,060.0	3,072,940.0	94.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,767,700.0	12,767,700.0		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,114,900.0	57,456,250.0	7,658,650.0	88.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,114,900.0	57,456,250.0	7,658,650.0	88.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65,114,900.0	57,456,250.0	7,658,650.0	88.2
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,326,808,600.0	1,315,561,577.3	11,247,022.7	99.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,148,550,700.0	1,148,550,700.0		100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,143,264,400.0	1,143,264,400.0		100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,286,300.0	5,286,300.0		100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,518,000.0	2,518,000.0		100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,768,300.0	2,768,300.0		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	178,257,900.0	167,010,877.3	11,247,022.7	93.7
132001	Орон нутгийн төсвөөс	178,257,900.0	167,010,877.3	11,247,022.7	93.7
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		205,922,233.4	(205,922,233.4)	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0		100.0
3	Төсвийн байгууллага	1.0	1.0		100.0
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.0	52.0		100.0
6	Удирдах ажилтан	4.0	4.0		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	35.0	35.0		100.0
8	Үйлчлэх ажилтан	14.0	15.0	(1.0)	107.1
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	546.0	531.0	15.0	97.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь *“Хүүхэд бүрийн хөгжлийг нь дэмжсэн асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааг насан туршийн боловсролын суурь чадвар эзэмшүүлэх ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган сургуулийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Иргэнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх,
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүй, мэдлэг ур чадвараа хөгжүүлж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байна.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 330,430.1 мянган төгрөгөөр буюу 36.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		205,922.2	205,922.2
Бараа материал	71,394.1	78,451.0	7,056.9
Үндсэн хөрөнгө	836,078.1	953,529.1	117,450.9
Нийт хөрөнгө	907,472.2	1,237,902.3	330,430.1
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	907,472.2	1,237,902.3	330,430.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	907,472.2	1,237,902.3	330,430.1

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 205,922.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,451.0 мянган төгрөг болж 7,056.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 145,173.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШУЯ-наас 2,018.9 мянган төгрөгийн түрээсийн ном, аймгийн БШУГ-аас 4,222.9 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын материал зэрэг

нийт 6,241.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, авч бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 144,358.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл *ланхны өртгөөр* 1,267,163.2 мянган төгрөг болж 170,129.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 33,741.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн болон спорт заалны барилгад 132,815.4 мянган төгрөгийн их засвар хийж хөрөнгийг капиталжуулсан, аймгийн БШУГ-аас 2,912.3 мянган төгрөгийн ном сурах бичиг, иргэдээс 660.0 мянган төгрөгийн принтер нийт 3,572.3 мянган хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,237,902.3 мянган төгрөг болж 330,430.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,160,925.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас төрийн үйлчилгээний ажилчдын цалин, нийгмийн даатгалын зардлыг 38369.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 1,199,294.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

2022 оны 05 дугаар сард орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний ажилчдын цалин улсын төсвөөс санхүүжигдэхээр болж төсөвт 3 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд 12 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа үйлчилгээний бусад зардал 64,675.4 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 62,838.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж улсын төсвөөс 1,143,264.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 178,257.9 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 5,286.3 мянган төгрөг нийт 1,326,808.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,143,264.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 178,257.9 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 5,286.3 мянган төгрөг нийт 1,326,808.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,109,639.3 мянган төгрөг буюу 83.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 174,015.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20,919.3 мянган төгрөгөөр, байр

ашиглалттай холбоотой зардлыг 1,778.6 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 7,658.7 мянган төгрөгөөр, дотуур байрны хоолны зардлыг 3,252.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 6,472.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,072.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3404.7	3404.7	0	100.0
		2	80312- Сургалт семинар	1702.4	790.2	912.2	46.4
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3915.4	3915.4	0	100.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	65114.9	57456.2	7658.7	88.2
		5	81806-Дотуур байрны үйлчилгээ	99473.9	93377.2	6096.7	93.9
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	29970	29970	0	100.0
		7	81823- Боловсролын багшийн сургалт	7660.6	5500	2160.6	71.8
		8	81834- Боловсролын стандарт сургалт	849645.2	662501.6	187143.6	78.0
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	82377.3	80426.9	1950.4	97.6
		10	83603-Сурах бичгийн түрээс	2768.3	2768.3	0	100.0
		11	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан	2518	2518	0	100.0
		12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	134657.1	132878.4	1778.7	98.7
		13	80112- Нийтлэг үйлчилгээ	43600.8	34132.4	9468.4	78.3
		Нийт		1,326,808.6	1,109,639.3	217,169.2	83.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100131155401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 6 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 940,059.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,400.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 174,015.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20,919.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 1,778.6 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 7,658.7 мянган төгрөгөөр,

дотуур байрны хоолны зардлыг 3,252.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 6,471.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,072.9 мянган төгрөгөөр нийт 217,169.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд мэдээллийн хэрэгжилт 91.2 хувьтай байна.

1. Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроосон,
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 4 удаа хугацаа хоцроосон,
3. Бусад мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 192 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 28,353.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	5,771.5			0.0
Нийт дүн	1	5,771.5			0.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар, өөрөөр хэлбэл өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалснаар тайлагнагдсан байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус сургуулийн цалин, НДШ-ийн зардлын төсвийг хүүхдийн тоо болон өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулалгүйгээр буюу өмнөх оны цалин, НДШ-ийн төсөв 694,941.2 мянган төгрөг байхад 2022 оны төсвийг 978,722.2 мянган төгрөгөөр

төсөвлөснөөс шалтгаалан гүйцэтгэлээр 783,787.0 мянган төгрөгийг зарцуулан 194,935.2 мянган төгрөгийн хэмнэлттэйгээр тайлагнагдсан байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 5,274.9 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлснээс 2,760.9 мянган төгрөгийн зөрчил төлбөрийн акт, 222.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,291.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1.1 Гүйцэтгэлийн үнэлгээгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн сургуулийн захирал П.Энхтуяад Баруунбүрэн сумын Засаг даргын 2022 оны 10 сарын 21-ний өдрийн Б/39 дугаар захирамжаар цалингийн 60 хувиар тооцож 709.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, захирлын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/50 дугаар тушаалаар сургалтын менежер Н.Алтанцэцэгт 725.9 мянган төгрөгийн, Д.Мөнхзулд 692.3 мянган төгрөгийн, нийгмийн ажилтан Ц.Мөнхжаргалд 633.2 мянган төгрөгийн зэрэг нийт 2,760.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон нь Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолын 4.4 дэх *“Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгоход энэ журмын 4.4.1, 4.4.2-т заасан шалгуур, үзүүлэлтийн дагуу ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, уг урамшуулалд зориулан батлагдсан тухайн жилийн төсөвт багтаан олгоно”* Боловсролын Шинжлэх Ухааны сайдын *“Чиглэл батлах тухай”* 2022 оны А/500 дугаар тушаалын хавсралт 3.1 дэх *“Нэмэлт урамшуулал олгох хязгаар 1-4 дүгээр түвшин 2-6 хувь”* гэсэн заалтууд болон БЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын А/343 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн урамшуулалд олгосон 2,760.9 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох,

5.2 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 222.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”* гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж хууль тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх,

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Цалин хөлстэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант оны төсөвт тусгаагүй байхад багш, ажилтнуудад 2,291.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг багш, ажилтнуудын 3 сарын дундаж цалингаас тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.Үндэслэлгүйгээр үр дүнгийн урамшуулал олгосон	1	2,760.9	1	2,760.9								
2.Төсөвт тусгагдаагүй зардал	1	2,291.8			1	222.2	1	2,291.8				

